

**АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ  
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

*/Жилийн эцсийн байдлаар/*

№	Д/д	Арга хэмжээ, зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024 он)	Зорилтот түвшин, (хэрэгжиж дуусах хугацаа)	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
		<b>Зорилт 1.Осол зөрчлийн мэдээллийг авах, ангилан бүртгэх</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Осол, зөрчлийн мэдээллийн санг үүсгэсэн.</b>	<b>Осол, зөрчлийн мэдээллийг ангилан бүртгэсэн</b>	<b>I-IV улирал</b>	<b>ЗСТ</b>
1	1.1	Аюулгүй ажиллагааг сайжруулах зорилго бүхий осол, зөрчлийн мэдээллийн санг хөтлөх.	Бүртгэлийн ажлын явц	Нийт 32 зөрчлийн тохиолдол ангилан бүртгэж, сан үүсгэсэн.	<b>Тухай бүр:</b> Мэдээллийг бүрэн авч, ангилан бүртгэж, санг хөтөлнө.	ИНЕГ-ын Эрэн хайх, авран туслах /ЭХАТ/-с нислэгийн саатал, зөрчил, дутагдлын 889 тохиолдлын мэдээ, МИАТ ХК-иас 46 мэдээ, Монголиан Эйрвэйс ХХК-с 5, Изинис Эйрвэйс ХХК-с 6, Аэромонголиа ХХК-с 10, Нью Клеве ХХК-с 3 мэдээ ирсэн. Нийт 42 зөрчлийн тохиолдлоос осол-1, ноцтой зөрчил-1, зөрчил-40 бүртгэгдсэн. Үүнээс: техникийн дутагдалтай холбоотой-5, дугуйтай холбоотой-3, цаг агаартай холбоотой-1, шувуутай холбоотой-12, 2-р тойрогт гарсан-18, битүүмж алдагдсан-1, цонхны шил цуурсан-1, бусад шалтгаант-1 тохиолдол гарсан байна. Тус бүрийг судлан үзэж ангилан, бүртгэх ажил хийгдэж байна.	100
2	1.2	Нислэгийн зөрчлийг бүртгэх мэдээлэх, цахим программын үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах.	Шинэчилсэн эсэх	Бүртгэлийн ECCAIRS v6.0 программыг цахим хуудсаар мэдээлэл байна. авч	<b>1 дүгээр улиралд:</b> Осол, зөрчлийг бүртгэх, мэдээлэх ажиллагааг бүрэн гүйцэт хийх, үйл ажиллагааг сайжруулсан байна. <b>2 дугаар улиралд:</b> Мэдээллийг цахимжуулах үйл ажиллагааг сайжруулж ECCAIRS v6.1 хувилбарыг ашиглана. <b>3, 4 дугаар улиралд:</b> Цахим хуудсаар мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг сайжруулсан байна.	Мэдээллийг цахимжуулах үйл ажиллагааг сайжруулж, ECCAIRS Web based v6.1 хувилбарыг ашиглан осол, зөрчлийн мэдээллийг бүрэн гүйцэт бүртгэн авч, ангиллыг нарийвчлан зөрчлийн жагсаалтыг шинэчлэн бүртгэж, сан үүсгэж байна. Осол, ноцтой зөрчил, зөрчил гэсэн 3 төрлөөр ангилан бүртгэж байна. Цахим хуудсаар сайн дурын болон албан байгууллагын мэдээлэл хүлээн авах ажиллагааг /имайл хаяг болон утсаар авах/ тогтмол хянаж байна. Цахим хуудасны ажиллагааг шинэчлэх талаар сервер хариуцагч байгууллагатай хамтран ажиллаж, 2025 оны 12 сард шинэ системээр цахим хуудас хийлгэж гэрээ хийн, төлбөрийг шилжүүлээд байна.	100

Зорилт 2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, шалтгаан нөхцөлийг тогтоох	Шинжлэн шалгах ажиллагааны явц	Эцсийн тайлан, урьдчилсан тайлан гаргах.	Шинжлэн шалгах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулсан байна.	I-IV улирал	ШШТ
<p>3 2.1</p> <p>Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил гарсан тохиолдолд шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан, дүгнэлт гаргах.</p>	<p>ШША явуулж, тайлан, дүгнэлт гаргасан эсэх</p>	<p>ШША 6 хийгдэж, 4 урьдчилсан тайлан 2 эцсийн тайлан гаргасан.</p>	<p>Тухай бүр: Осол, ноцтой зөрчлийн үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан гаргана. Зөрчлийн үндсэн шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлсон урьдчилсан тайлангийн төслийг холбогдох газруудад хүргүүлж, санал авна. Эцсийн тайланг холбогдох байгууллагуудад болон ОУИНБ-д англи хэл дээр хөрвүүлэн хүргүүлнэ.</p>	<p>"Монголиан Эйрвэйз" ХХК-ний Н125 маягийн JU-8888 бүртгэлийн дугаартай нисдэг тэрэг осолдсон шалтгааныг тогтоох шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- техник үйлчилгээнүүдийг шалгах ажиллагаа</li> <li>- хөдөлгүүрийг засах үйл ажиллагааны байдалд судалгаа хийх</li> <li>- Их засвар хийсэн Хятад дахь нисдэг тэрэгний засварын газартай хамтран ажиллаж, техникийн баримт бичгүүдийн судалгаа хийх</li> <li>- "Монголиан Эйрвэйз" ХХК-ийн Техник үйлчилгээний зааврууд, нислэгийн үйл ажиллагааны заавар В, Нислэгийн сургалтын зааврын судалгаа,</li> <li>- Нисгэгчийн мэдээлэл, хүний хүчин зүйлийг судалж, шалгах ажиллагаа хийгдэв.</li> </ul> <p>Эцсийн тайлан, дүгнэлтийг гаргаж, Иргэний нисэхийн ерөнхий газарт 2025.01.27-ны 07/25 тоот, Монголиан Эйрвэйс ХХК-д 2025.01.16-ны 06/25 тоот, Зам, Тээврийн сайдад 2025.01.27-ны 08/25 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлсэн.</p> <p>-ИНД-149 /Нисэх клубын гэрчилгээжүүлэлт/ дүрмээр гэрчилгээжсэн "Нью Клеос" ХХК-ийн Evektor Sportstar MAX маягийн, JU-9088 бүртгэлийн дугаартай агаарын хөлөг 2024.03.30-ны өдөр "Буянт-Ухаа" нисэх буудалд буулт үйлдэж байхдаа эвдрэлд орж хөөрч буух зурвасны хажуугийн хяналтын шугаман дээр зогссон ноцтой зөрчлийг тус албанаас шинжлэн шалгасан Эцсийн тайланг ЗТХЯ-ны Сайд Б.Дэлгэрсайханд 2024.12.17-ны 83/24 тоот, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад 2024.12.16-ны 81/24 тоот, Нью Клеос ХХК-д 2024.12.17-ны 82/24 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>- "Нью Клеос" ХХК-ийн Safari VLA JU-9099 дугаартай агаарын хөлөг 2024 оны 06 сарын 18-ны өдөр талбай сонгон аргагүйдсэн буулт үйлдсэн зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа хийгдсэн. Тайлангийн төслийг ИНЕГ-т 2024.12.26-</p>	<p>100</p>

					<p>ны 85/24, Нью Клеос ХХК-д 86/24 тоотгоор хүргүүлсэн, Эцсийн тайланг 2025.01.25-ны 03/25 тоотгоор ИНЕГ-т, 04/25 тоотгоор Нью Клеос ХХК-д, 05/25 тоотгоор ЗТС-д хүргүүлсэн.</p> <p>Шинжлэн шалгах ажиллагааны нийт 3 эцсийн тайлан, 2 урьдчилсан тайлан гаргасан байна.</p> <p>- Нью Клеос ХХК-ний Sportstar Max, JU8060 бүртгэлийн дугаартай агаарын хөлөг Буянт-Ухаа – Баянхонгор чиглэлийн нислэгийн үед сэлхинд цохиулж унасан шалтгааныг тогтоох шинжлэн шалгах ажиллагаа явагдаж байна.</p> <p>- МИАТ ХК-ний EI-MNG, B737MAX8 агаарын хөлөг 2025.08.04-ний өдөр Токио-УБ чиглэлийн нислэгийн үед бүхээгийн битүүмж алдагдсан шалтгааныг тогтоох шинжлэн шалгах ажиллагаа явагдаж байна. Тушаалын дагуу баг томилогдсон. /Хавсаргагч/</p>	
4	2.2	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед болон шаардлагатай тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаа явуулж, тайлан, дүгнэлт гаргах.	ШША явуулж, тайлан, дүгнэлт гаргасан эсэх	ШША хийж, тайлан, дүгнэлт гаргасан.	<p><b>Тухай бүр:</b> Осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан дүгнэлт гаргана.</p> <p>МИАТ ХК-ний JU-1088, B737-800 агаарын хөлөг 2024.02.27-ны өдөр HKG-UBN чиглэлийн нислэгийн үед бүхээгийн битүүмжлэл алдагдсан шалтгааныг тогтоох, НТӨЗШША-ны даргын 2024.03.01-ний А/04 трот "Шинжлэн шалгах багийг томилох тухай" тушаал гаргасан. Хийгдсэн ажиллагаа: B737-800 агаарын хөлгийн бичлэг тайлах ажиллагаа, тоног төхөөрөмж, эд ангийн техникийн судалгаа, дүгнэлт хийх, ашиглалтын заавар журмын биелэлт, нисэх багийн сургалт, ур чадвар, гэрчилгээжүүлэлтэд судалгаа, шинжилгээ хийх г.м. Шинжлэн шалгах ажиллагаа явагдаж эцсийн тайлан гаргасан. /2025.05.05-ны 30/25 албан тоотгоор ИНЕГ-т, 31/25-р МИАТ ХК-д, 2025.05.08-ны 33/25 тоотгоор ЗТЯ-нд тус тус хүргүүлсэн.</p> <p>-МИАТ ХК-ний B737-800, EI-CXV агаарын хөлөг 2025.02.24-ний өдөр Хонг-Конг-УБ нислэгийн үед бүхээгийн даралтын хэвийн ажиллагаа алдагдсан байж болох зөрчил гарсныг шинжлэн шалгах ажиллагаа хийгдэж байна.</p> <p>-Альфа Аврора эвэйшн ХХК-ын А\$350 В3 маягийн JU-6555 дугаартай агаарын хөлөг 2025 оны 07 сарын 21-ны өдөр Увс аймгийн Өмнөговь сумын нутагт авто уралдааны зураг авах үед даах сэнсний алганд гадны биеийн цохилтоос гэмтэл үүссэн шалтгааныг шинжлэн шалгах ажиллагаа хийгдэж тайлан дүгнэлт гаргасан. Тайлаккийн төслийг 2025.08.29-ны 51/25 тоотгоор ИНЕГ-т, 2025.08.29-ны 52/25 тоотгоор Альфа Аврора ХХК-д тус тус хүргүүлсэн.</p>	100

						Эцсийн тайланг 2025.12.02-ны 66 тоотор ИНЕГ-т, 2025.12.02-ны 67 тоотор Альфа аврора ХХК-д, 2025.12.08-ны 71 тоотор ЗТЯ-д тус тус хүргүүлсэн.	
<b>Зорилт 3. Осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой аюулгүй байдлын зөвлөмж гаргах</b>		<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Аюулгүй байдлын арван зөвлөмж гаргасан.</b>	<b>Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаулсан байна.</b>		<b>I-IV улирал</b>	<b>ШШТ</b>
5	3.1	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны тайланг үндэслэн нислэгийн аюулгүй байдлын зөвлөмж гаргах /АБЗ/	Аюулгүй байдлын зөвлөмж гаргасан эсэх	7 зөвлөмж гаргаж хүргүүлсэн.	<b>Тухай бүр:</b> Нислэгийн ажиллагааг зорилгоор шалгасан дүгнэлтийг осол, зөрчил гарахаас сэргийлэх байдлын зөвлөмжүүдийг гаргана.	Иргэний нисэхийн тухай хуулийн 9-р бүлэг, албаны дүрмийн дагуу аюулгүй байдлын зөвлөмж гаргадаг, шинээр 3 зөвлөмж, /2024 оны 12 сард ерөнхий зориулалтын агаарын хөлгийн ноцтой зөрчилтэй холбоотой - 4, 2025 онд зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд аюулгүй байдлын 4 зөвлөмж/ гаргасан байна. Үүнд: ЗӨВЛӨМЖ 202412/08 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202412/09 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202412/10 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202412/11 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202501/01 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202501/02 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202501/03 - ИНЕГ-т ЗӨВЛӨМЖ 202501/04 - ИНЕГ-т	100
6	3.2	Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэн хяналт тавьж, тайлагнах	Тайлангийн тоо	Зөвлөмжийн биелэлтийг улирал бүр тайлагнасан.	<b>Тухай бүр:</b> Аюулгүй зөвлөмжийн хэрэгжилтийг авч, хэрэгжилтэд тавьж, танилцуулна.	Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаас авч, тайланг судалж үзээд 2025.11.28-ны байдлаар биелэлтийг дүгнэх ажиллагаа хийгдсэн. Тайлангийн хугацаанд хяналтад байгаа 18 зөвлөмжөөс: 100%-тай 2, 50%-тай 3, 30%-тай 8, 0%-тай буюу хэрэгжээгүй 6 зөвлөмж байна. Биелэлт 31,05 хувьтай байна. /файл хавсаргав/ Шинжлэн шалгасан ажиллагааны үр дүнг үндэслэн агаарын хөлгийн осол, зөрчил дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг улирал тутамд дүгнэдэг бөгөөд 2025.03.25-ны байдлаар гарган ИНЕГ-т 2025.03.31-ний 20/25 тоот, 2025.04.23-ны 25/25 тоот бичгээр 2025.06.18-ны 37/25 тоотор ЗТЯ-нд, 2025.07.09-ний 40/25 тоотор ЗТЯ-д, 2025 оны 11-р сарын 28-ны өдрийн байдлаар гарган 2025.12.04-ний өдрийн 69 тоотор ЗТЯ-д тус тус хүргүүлсэн.	100

Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	Хэрэгжилтийн явц	Санамж бичиг байгуулсан	Шинжлэн шалаагч ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг авч, туршлага солилцон, гадаад хамтын ажиллагааг сайжруулсан байна.	I-IV улирал	ЗСТ, ШШТ
7 4.1 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтоосон хугацаанд байршуулах.	Байршуулсан мэдээллийн тоо	Холбогдох мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулан мэдээлдэг. 24 цагийн мэдээлэл дамжуулах утас, жижүүр шинжлэн шалгагч ажиллуулж байна.	<b>Тухай бүр:</b> ОУИНБ болон гадаад улс орны агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зорилго, ач холбогдлыг олон нийтэд тухай бүр танилцуулж бүртгэлчилнэ. Мэдээллийг цахим хуудсанд мэдээллийн байршуулна. Цахим болон самбарт	Албаны үндсэн чиг үүргийн дагуу шинжлэн шалгах ажиллагааг явуулж, агаарын хөлгийн осол, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоож, гаргасан тайлан, дүгнэлт, аюулгүй байдлын зөвлөмжүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлж байна. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж, мөрдөж байгаа бүх хууль тогтоомж, дүрэм журам, хүний нөөцийн үйл ажиллагаанд хамраах эрх зүйн баримт бичиг, тушаал шийдвэрүүдийг цахим хуудсанд байршуулж, шинэчилж байна. Албаны даргын гаргасан нийтэд хамраатай тушаал, шийдвэрийг он, оноор нь гаргасан ба агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн бүртгэл судалгаанд суурилан осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийн, статистик судалгаа гарган, байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлдэг. Сул орон тоонд 2 ажилтан шинээр авч ажиллуулж байна. /Нягтлан бодогч, гадаад харилцааны мэргэжилтэн/ Цахим хуудсыг шинэ системээр дахин боловсруулж, шинэчлэн засварлах ажил хийгдэж байна, 14 мэдээлэл оруулан байршуулсан бөгөөд албаны мэдээллийн самбарт тухай бүрд байршуулан мэдээлж байна.	50
8 4.2 Албаны гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны асуудлыг зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	Агаарын хөлгийн үйлдвэрлэгч, зохион бүтээгч, эзэмшигч улсууд, санамж бичиг байгуулсан шинжлэн шалгах байгууллагуудтай агаарын хөлгийн осол, ноцтой	<b>Тухай бүр:</b> Шинжлэн шалгах ажиллагаанд тухай бүр хамтарч ажиллана, шинжлэн шалгагчдийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг авч, туршлага солилцон, гадаад хамтын ажиллагааг сайжруулсан байна. 2-3 сургалт, үйл ажиллагаа зохион байгуулна.	Албаны нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан олон улсад зарлан мэдээлэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэв. Шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд Франц улсын Шинжлэн шалгах байгууллага /BEA/, БНХАУ дахь Аэробусын төлөөлөгчийн газар, ИКАО-ын Ази, Номхон далайн орнуудын Шинжлэн шалгах байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцож байна. Конвенцийн 13-р Хавсралтад заасны дагуу агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн үед тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч, эзэмшигч, зохион бүтээгч, хөдөлгүүрийн үйлдвэрлэгч, эзэмшигч орнуудтай харилцан мэдээлэл солилцож, техникийн дүгнэлт хийн, шинжлэн шалгах ажиллагааг явуулж байна. Албаны 2025 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж баталсан.	100

			зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд хамтран ажиллаж байна.		Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудит хөтөлбөр, байнгын аргачлалын хүрээнд зохион байгуулагдсан ОУИНБ-ын Ази номхон далайн бүсийн техникийн туслалцаа үзүүлэх багийн шалгалтын дагуу гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын ерөнхий төлөвлөгөө гарган 2025.09.29-ны 56/25 тоот албан бичгээр ЗТЯ-д хүргүүлсэн. Иргэний нисэхийн осол зөрчлийн үед хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг ИКАО-ын Док 9756-н 1-р хэсэг 3-н 2 бүлэгт заасны дагуу шинэчлэн өөрчлөлт оруулсан төслийг МИАТ ХХК-нд 2025.12.10-ны 73 тоот, Изинис Эйрвэйс ХХК-д 2025.12.10-ны 74 тоотор хүргүүлсэн. Иргэний нисэхийн ерөнхий зориулалтын агаарын хөлөг болон хэт хөнгөн агаарын хөлгүүдийн аюулгүй байдлыг хангах зориулалтыг судалж хэрэгжүүлэх зорилгоор АНУ-ын Миссури мужын Branson, Spring Field хотуудын жижиг оврын агаарын хөлгийн сургалтын байгууллагууд Premier Flight center, IFR flight club, Tri-Lakes RC Flying Club-т ажиллуулахаар ахлах шинжлэн шалгагч Х.Наранхүүг 2025 оны 12 сарын 11-ний өдрөөс 22-ны өдрүүдэд томилолтоор ажилласан. Гадаад улсад 2025 онд нийт 3 сургалт, семинар, судалгааны ажил хийгдсэн. /100%/ ИКАО-оос Монгол улсад 2026 оны 04-р сард Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон улсын аудит хөтөлбөр, байнгын хяналт аргачлалын хүрээнд хийгдэх шалгалтын бэлтгэл ажлыг ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөний дагуу хийж эхлүүлээд байна.		
9	4.3	АХОЗШЦА-ны дүрэмд өөрчлөлт оруулж, батлуулах.	Батлуулсан дүрмийн тоо	ЗТХ-ийн сайдын 2022.03.28-ны А/73 тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.	1 дүгээр улиралд: Албаны дүрмийг Зам, Тээврийн сайдын тушаалаар батлуулсан байна.	Хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2024 оны 12 сарын 31-ний өдрийн "Бүтэц орон тоо, дүрэм батлах тухай" А/298 дугаар тушаалаар албаны нэрийг Агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах алба болгон өөрчилж, бүтэц, орон тоо, дүрмийг батлуулсан. Албаны дотоод үйл ажиллагааны заавар, журмуудыг шинэчлэх ажил хийгдсэн. Үүнд: Шинжлэн шалгах үйл ажиллагааны заавар 558х, Сургалтын заавар 57х, Шинжлэн шалгах ажиллагааны Check-list журам 137х, Хөдөлмөрийн дотоод журам 37х, Хамтын гэрээ гэх мэт. Мөн албаны үйл ажиллагаа, шинжлэн шалгах ажиллагааны англи хэл дээр байгаа заавруудыг Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж байна. Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 9 дүгээр бүлэгт	70

					нэмэлт өөрчлөлтийг оруулан 2025.10.17-ны 58/25 тоот албан бичгээр ЗТЯ-д, 2025.12.04-ний 70 тоотбор ИНЕГ-т 2025.12.09-ний 72 тоотбор тус тус хүргүүлэв.	
<b>ТАВ. ТӨСӨВ, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ</b>						
<b>-Зорилт 5. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах.</b>		<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Төсөв баталсан, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн нөөц бүрдүүлсэн.</b>	<b>Төсвийн алдагдалгүй, зөрчил дутагдалгүй хэрэгжүүлсэн байна</b>	<b>I-IV улирал</b>	<b>ЗСТ</b>
10	5.1	Албаны 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулах, хөрөнгө, санхүүгийн бүртгэл хөтөлж, хагас болон бүтэн жилийн тайлан гаргах.	Төсвийг батлуулсан, тайлагнасан эсэх	ИНЕГ-ын төсөвтэй хамт хэрэгждэг. Албаны төсөв, хөрөнгийн бүртгэлийг хөтөлж тайлагнасан.	<p>Монгол улсын Зам Тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ны А/198 тушаалаар Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны нэр Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба гэж өөрчлөгдсөн.</p> <p>ИНХ-ийн дагуу үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт шинээр бүртгүүлэх, гэрчилгээ авах, тамга тэмдэг хийлгэх, данс нээх ажиллагааг хийж гүйцэтгэв.</p> <p>2025 оны зардлын төсвийн төслийг 2025.01.10-ны 02/25 тоот албан бичгээр ЗТЯ-д хүргүүлсэн.</p> <p>Албаны төсвийн зардлыг ИНЕГ-аас тусдаа 12 хүний орон тоотойгоор батлуулж, шинээр санхүү, нягтлан бодогч, гадаад харилцааны мэргэжилтэнг авч ажиллуулаад байна.</p> <p>Эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн тооллогыг хийж, бүртгэлийг баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>ХХОАТ, НДШ-ийг 3-11-р сарын тайланг өгсөн, Шилэн данс нээлгэж, хугацаанд нь мэдээллийг оруулсан.</p> <p>Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 4.2.1, дэх заалтын дагуу Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны хэвлэмэл хуудасны эх загварыг Архивын ерөнхий газраар хянан баталгаажуулсан. /2025.07.02-ны 39/25/</p> <p>Албаны 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг боловсруулан 2025.07.09-ний 41/25 тоот албан бичгээр ЗТЯ-д хүргүүлсэн.</p>	100
11	5.2	Шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, хөдөлмөр	Батлуулсан төсвийн тоо, бүрдүүлсэн нөөцийн тоо, бэлэн байдалд байгаа эсэх	Тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн 6 багц нөөц бүрдүүлсэн.	<p><b>1, 2 дугаар улиралд:</b></p> <p>Иж бүрдэл, хэрэгсэл, төхөөрөмжийн судалгааг гаргаж нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай төсөв,</p>	100

		хамгааллын хувцас хэрэглэл зэргийн нөөцийг бүрдүүлж, байнгын бэлэн байдалд байлгах.			тооцоог гаргаж батлуулсан байна. <b>3, 4 дүгээр улиралд:</b> Нормын дагуу бэлтгэж, бэлэн байдалд байлгана. Нэмэлт шаардлагатай төсвийг 2026 оны төсөвт тусгана.	хувцас авахад 4450000 төгрөг, 9 хүний зуны хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлд 1485000 төгрөг, ажилтнуудын компьютеруудыг шинэчлэх, ухаалаг самбар, архивын сейф, автомашины сэлбэг зэрэгт 57800000 төгрөг, нийт ажилтнуудын /9 хүн/ эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 3564000 төгрөг тус тус зарцуулсан.	
12	5.3	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг хадгалах, дэмжих, урамшуулах үйл ажиллагааг хийж гүйцэтгэх	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо, Сургалтын төлөвлөгөө батлуулсан эсэх	2024 онд төсөв, санхүүгийн улмаас хэмнэлтийн горимд ажиллаж, албан хаагчдыг мэргэшүүлэх, урамшуулах, дэмжих үйл ажиллагаа хийгдэж, 3 ажилтан хамрагдсан.	<b>1 дүгээр улиралд:</b> Хүний нөөцийн бодлого бодовсруулах ажиллагааг эхлүүлж, сургалтын төлөвлөгөө гаргаж батлуулна. <b>2 дугаар улиралд:</b> Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. <b>3, 4 дүгээр улиралд:</b> Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, зохион байгуулсан ажлыг тайлагнасан байна.	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны 2025 оны хүний нөөцийн мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг гаргаж батлуулсан. АХОЗШША бие даан үйл ажиллагаа явуулж эхлэж байгаатай холбогдуулан албан хаагчдын цалин, урамшуулал болон тоног төхөөрөмжийг хэрхэн сайжруулах талаарх судалгаа хийж, төсвийн дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанд эрэлттэй байгаа ажлын байр, шаардлагатай ажиллах хүчний мэдээллийг шинэчлэн гаргасан. Нисэх хүчин үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ажиллагсдыг шагнаж урамшуулах талаар албан бичгийг ИНЕГ-т 2025.02.05-ны 12/25 тоотор хүргүүлсэн. Нийт 6 ажилтныг төрийн болон Иргэний нисэхийн байгууллагын шагналаар шагнаж урамшуулсан. Гавьяат техникч 1, Алтан гадас одонгоор 1, хүндэт ажилтан тэмдэг 1, хүндэт дэвтэрт нэр бичих -2, жуух бичиг 1 ажилтан шагнагдсан. -ИКАО болон Олон улсын нисэхийн аюулгүй байдлын шинжлэн шалгах нийгэмлэг (ISASI)-ээс АНУ-ын Денвер хотод зохион байгуулагдаж байгаа сургалт-сөмйнарт 2025.09.26-10.06-нд албаны дарга Ж.Цолмон оролцсон. -ИКАО болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудит хөтөлбөр байнгын хяналтын аргачлал (USOAPCMA)-ын шалгалтад бэлтгэл ажлын хүрээнд Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулагдаж байгаа сургалтад шинжлэн шалгагч Г.Ганхуяг, Ч.Шинэбаяр нар 2025.11.08-15-ны өдрүүдэд хамрагдсан. Нийт 2 сургалтад 3 хүн хамрагдсан. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 75 хувьтай байна. Сургалтын удирдамж тайланг гаргаж хугацаанд нь тайлагнасан.	75

**ЗУРГАА. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

<b>Зорилт 6. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах.</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>	<b>Судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлтийг ЗТХЯ-нд хүргүүлсэн.</b>	<b>Холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан байна.</b>	<b>I-IV улирал</b>	<b>ЗСТ</b>
<p>13 6.1 Иргэний нисэхийн осол, зөрчлийн мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийх.</p>	<p>Дүн шинжилгээ хийх ажлын явцыг тайлагнасан эсэх</p>	<p>2010-2024 онд гарсан осол, зөрчлийн мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлтийг ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p>	<p><b>1 дүгээр улиралд:</b> Судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлнэ. <b>2 дугаар улиралд:</b> Осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийнэ. <b>3, 4 дүгээр улиралд:</b> Мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, тайлбар гарган тайлагнасан байна.</p>	<p>Албаны мэдээллийн сан бүртгэл, осол, ноцтой зөрчлийн мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийж, зөрчил давтагдан гарсан тохиолдолд дүн шинжилгээг жил бүр хийдэг бөгөөд "осол, зөрчлийн бүртгэл, статистик судалгааг сүүлийн 5 жилээр гарган дүн шинжилгээ хийж байна. Судалгаа шинжилгээний ажлын хүрээнд гарсан тайлбар дүгнэлтийг цахим хуудас болон мэдээлийн самбарт байршуулан мэдээлж байна. -Зам, тээврийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ерөнхий зориулалтын болон бага оврын агаарын хөлгийн ашиглалтын талаар тус албанаас судалгаа, дүн шинжилгээ хийж, гүйцэтгэсэн тайланг ЗТХЯ-д 2025.04.29 27/25 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>	<p align="center">90</p>
<p>14 6.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, СЗХШ-ийн хэрэгжилт, ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг ханган тайлагнах</p>	<p>Тайлагнасан ажлын тоо</p>	<p>Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ЗТХЯ-ны ТЗУГ, ХШҮДАГ-т тайлагнасан.</p>	<p><b>Тухай бүр:</b> Биелэлтийг бүрэн гарган хугацаанд нь тайлагнана.</p>	<p>Зам, Тээврийн сайдын 2024.12.31-ний Б/13 дугаар тушаалын дагуу АХОЗШША-ыг байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн. 8112738 регистрийн дугаартай, төрийн байгууллага, албан газрын гэрчилгээ авсан. Тамга тэмдэг шинээр хийлгэн, Голомт банканд 1305012297 тоот харилцах данс нээлгэсэн. Батлагдсан орон төөнд нийцүүлэн төсвийг батлуулаад байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тушаалын биелэлт, СЗХШ, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт зэргийг цаг тухайд нь бүрэн тарааж хүргүүлсэн бөгөөд нийт 4 удаа улирал бүр тайлагнасан байна.</p>	<p align="center">70</p>
<b>ДОЛОО. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ</b>					
<p><b>Зорилт 7. Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацаа (2020-2024)-ны дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах</b></p>	<p><b>Цахимжуулах ажлын явц</b></p>	<p><b>2022 оны байдлаар</b></p>	<p><b>Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулсан байна.</b></p>	<p><b>I-IV улирал</b></p>	

15	7.1	Ажилтан, хаагчдын гарын хэрэглээг нэмэгдүүлж, албан хөтлөлтөд ашиглах	албан тоон үсгийн хэрэг	Тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлсэн эсэх	Шинжлэн шалгагч 2 хүний тоон гарын үсгийн хэрэглээг нэмж нэвтрүүлсэн..	<p><b>1, 2 дугаар улиралд:</b> Ажилтнуудын тоон гарын үсгийн хэрэглээг албан бичиг хөтлөлтөд нэвтрүүлнэ.</p> <p><b>3, 4 дүгээр улиралд:</b> Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, албан хэрэг хөтлөлтөд бүрэн ашигласан байна.</p>	<p>Үйл ажиллагааны онцлогоос хамаарч албаны дарга, ахлах шинжлэн шалгагчид тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэн албаны бичиг хэрэгт ашиглаж байна.</p> <p>Орон тоо бүтэц өөрчлөгдсөн тул нэмж 1 ажилтанд тоон гарын үсгийн төхөөрөмж авч, бичиг хэргийн хэрэглээнд нэвтрүүлсэн.</p> <p>Эйбл программд 2 хүний эрх нээлгэн албан бичиг хэрэг хөтлөлтөнд ашиглаж, бүх бичиг хэргийн ажиллагааг цахимжуулсан.</p>	100
16	7.2	Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх		Шинэ техник технологи нэвтрүүлсэн эсэх	2024 онд төсөв, санхүүгийн улмаас шинэ технологи нэвтрүүлэх ажиллагаа хийгдээгүй байна.	<p><b>1, 2 дугаар улиралд:</b> Шинэ технологи нэвтрүүлэх санхүүжилтийг шийдвэрлэх, төлөвлөгөө гаргах</p> <p><b>3, 4 дүгээр улиралд:</b> -Төлөвлөгөөний дагуу ажлыг бүрэн гүйцэтгэж хийсэн байна. -Шинэ технологи нэвтрүүлсэн тайланг ЗТЯ-д танилцуулсан байна.</p>	<p>Албаны үндсэн чиг үүрэг осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл болон бүхээгийн яриа бичлэгийн төхөөрөмжийн /FDR/CVR/ бичлэгийг тайлж унших ажиллагааг сайжруулах зорилгоор</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шинэ программ хангамж /-50% хөнгөлөлттэй/</li> <li>- Тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийг судалж, нэвтрүүлэхээр төлөвлөж, төсвийн дагуу албан ёсны лицензтэй программ хангамж, компьютер тоног төхөөрөмжүүдийг 144,2 сая төгрөгөөр худалдан авсан.</li> </ul> <p>Судалгааны үндсэн дээр Канад улсын шинэ технологи, системээр хийгдсэн программ хангамж, хамгийн сүүлийн үеийн үзүүлэлт бүхий 3D график бүхий компьютерийг худалдан авсан. Нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, шинжлэн шалгах ажиллагаанд шинэ тоног төхөөрөмж, программ хангамжийг нэвтрүүлэн ашиглаж эхлээд байна.</p>	100

Төлөвлөгөө хянасан:

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Төлөвлөгөө тайлагнасан:

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА

**Төсвийн ерөнхийлөн захирагч**  
  
 Б. ДЭЛГЭРСАЙХАН

**Төсвийн шууд захирагч**  
  
 Ж.ЦОЛМОН

ЭСТБ:  
 Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:  
 Захиргаа, судалгааны тасаг, техникийн шинжлэн шалгагч  
 П.Гэрэлчимэг  
 Холбоо барих утас: 71285099  
 Цахим шуудан: aaib@aaib.gov.mn